



БЯЦХАН
МОНГОЛ
ЦЭЦЭРЛЭГ



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Бяцхан Монгол” цэцэрлэг 2016.09.01-нд, “Бяцхан Монгол” дөрвөн улирлын цэцэрлэг 2017.11.06-нд үүсгэн байгуулагдсан. Одоогоор Баянзүрх дүүргийн салбарт 6 бүлэг, Хан-Уул дүүргийн салбарт 4 нийт 10 бүлэгт (бага 55, дунд 55, ахлах 60, бэлтгэл 120) 300 гаран хүүхдэд 50 гаруй багш ажилтан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хичээнгүйлэн хүргэж байна. Бид 2023.01.01-с эхлэн Хан-Уул дүүргийн 16-р хороонд шинээр хүүхэд хөгжлийн төвтэй хослуулсан шинэ салбарыг нээж үйл ажиллагаагаа өргөжүүлж байгааг дуулгахад таатай байна.

БИЕ ЧИЙРЭГ, БИЛИГ ИХ, СЭТГЭЛ ЗӨВ шинэ монголын үрсийг бэлтгэх, насан туршийн чанартай боловсролын суурь чадварыг эзэмшүүлэх “Жишиг цэцэрлэг”-г томъёолж түүчээлэх зорилготой. Манай хамт олон өнгөрсөн 8 жилд хуримтлуулсан туршлага багагүй ч цаашид ихийг хийж бүтээх гал хүсэл эрмэлзэл дүүрэн байна.



Манай хамт олон:

- ▶ Цэцэрлэгийн хөгжлийн бодлого төлөвлөлт
- ▶ Сургалтын онцлог, өдрийн дэглэм, багш ажилтны хийж гүйцэтгэх ажил үүрэг,
- ▶ Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүд
- ▶ Хүүхэдтэй ажиллахдаа анхаарах зүйлс
- ▶ Хүүхэд бүрийн ялгаатай байдлыг тооцох
- ▶ Цэцэрлэгийн багш ажилтны ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх
- ▶ Эрүүл ахуй хоол хүнсний аюулгүй байдлыг хангах
- ▶ Аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх
- ▶ Хүүхдийг судлах ажиглах, үнэлэх, оношлох арга барилд суралцах
- ▶ Эцэг эхэд үйлчилгээ үзүүлэх арга барилд тасралтгүй суралцаж, хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

Та бид хамтдаа нэг зорилгын төлөө тэмүүлж, бие биенээ дэмжиж хамтран ажиллаж чадна гэдэгт итгэлтэй байна.

Хүүхэд бүр инээд хөөр, хүсэл эрмэлзэл дүүрэн эрүүл энх өсөн торних болтугай.







ХЭТИЙН ЗОРИЛГО *Vision*

Бие чийрэг, Билиг их, Сэтгэл зөв
шинэ монголын үрсийг бид бэлтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Mission

Хүүхдийн бие, сэтгэл, оюуны хөгжлийг томъёолон шилдэг арга зүйг бий болгох, хүүхдийг дээдэлсэн үйлчилгээ бүхий улсынхаа хүн амын хөгжилд хувь нэмэр оруулах байгууллага байна хэмээн бид эрхэм зорилгоо тодорхойлсон.



ҮНЭТ ЗҮЙЛС *Values*



Хүүхдийг хайрлах зүрх сэтгэл: Эцэг, эхийн сэтгэлээр хүүхдэд хандаж эерэг дулаан харьцааг бий болгон уйгагүй хөгжүүлж, хүмүүжүүлдэг.



Мэргэшсэн байдал: Мэргэжлийн өндөр ур чадвартай, гүйцэтгэлээ дүгнэж тасралтгүй өөрийгөө болон бусдыг хөгжүүлдэг.



Хариуцлагатай байдал: Үүрэгт ажилдаа хариуцлагатай хандаж, мэргэжлийн ёс зүйг баримтлан ажилладаг.



Багийн ажиллагаа: Зорилгодоо хүрэхийн тулд харилцан итгэлцэл, хүндлэлийг буй болгон үр дүнтэй хамтран ажилладаг.



Үнэнч шударга байдал: Монгол улсын хууль журмыг сахин дээдэлдэг, аливаад үнэнч шударга ханддаг.

СУРГАЛТЫН ЦӨМ ХӨТӨЛБӨР

Манай цэцэрлэг нь “Хайр, Хүндлэл, Хүсэл эрмэлзэл” хэмээх эрхэм зорилгынхоо хүрээнд хүүхдийн “**Биеийн хөгжил, Сэтгэлийн хөгжил, Оюуны хөгжил**” гэсэн тулгийн 3 чулууг баримтлан өөрсдийн туршлага дээрээ хөгжүүлсэн хөтөлбөрийг чиглэл болгон үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

“ БИЕИЙН ХӨГЖИЛ

- Хоол шим тэжээлийн хөтөлбөр
- Биеийн тамирын үндсэн хөтөлбөр
- Бие бялдрын хөгжлийг дэмжих дугуйлангууд
- Арга хэмжээ бүхий спорт өдөрлөгүүд
- Эрүүл мэндийн байнгын үзлэг оношлогоо
- Хүүхдийн өсөлт, Эрүүл мэндийн дэвтэр

ТОГЛО

СУРАЛЦ

ХӨГЖ



“ ОЮУНЫ ХӨГЖИЛ

- Дүрслэх урлагийн хөтөлбөр
- Тоо тоолол, математик энгийн төсөөлөл хөтөлбөр
- Дуу хөгжим, хэл ярианы хөгжил хөтөлбөр
- Сурагч болох бэлтгэлд зориулсан нэгдсэн цогц хөтөлбөр
- Бяцхан Монгол цэцэрлэгийн дасгал ажлын дэвтэрүүд

“ СЭТГЭЛИЙН ХӨГЖИЛ

- Зүрх сэтгэлийн дасгал хөтөлбөр
- Нийгэм сэтгэл хөдлөл, ёс зүйн хөтөлбөр
- Нийгэмшихүйн хөтөлбөр
- Бяцхан монгол цэцэрлэгийн соёл









ЯАГААД

БЯЦХАН МОНГОЛ ГЭЖ



Сонгох шалтгаан

Ном, Сурах бичиг, Хэрэглэгдэхүүн

Сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичгээ өөрсдийн туршлага болон судалгаан дээрээс үндэслэн хэвлэж бэлддэг ба манай гаргасан сурах бичгийг бусад цэцэрлэгүүд мөн үйл ажиллагаандаа тодорхой хэмжээнд ашигладаг.

Гурвалсан харилцаа буюу тулгын 3 чулуу

Эцэг эх, Асран хамгаалагч болон Багш-Цэцэрлэг гэсэн гурвалсан харилцааг нэн тэргүүнд тавьдаг ба онлайн болон цаасан харилцах дэвтрийг үргэлж хөтлөн эцэг эхтэй хамтран ажилладаг. Гурвалсан уулзалтыг зохион байгуулахдаа эцэг эхтэй ганцаарчлан уулзаж тухайн хүүхдийн өсөлт, хөгжлийн асуудлаар мэдээлэл өгч, зөвлөлдөнө. Хүүхдэд хүргэж буй үйлчилгээний чанарыг сайжруулах, ажлаа дүгнэхэд эцэг эх, асран хамгаалагч та бүхний санал, зөвлөгөө хэрэгтэй байдаг. Мөн бид энэхүү уулзалтаас эцэг эх, асран хамгаалагчаас гарсан санал, зөвлөмжийг харгалзан багшийн ажлыг дүгнэж, ур чадварыг нь сайжруулахад анхаарч ажилладаг.

Эрүүл, Тэжээллэг хоол хүнс

Хүүхэд нь аливаа улс орны нийгмийн толь, маргаашийн хөгжлийг авч явах үүрэгтэй хүмүүс. Иймээс Хүүхэд багаасаа зөв хооллож сурах нь ирээдүйд эрүүл чийрэг насанд хүрсэн хүн болоход маш чухал юм. Манай хүүхдүүд хоолны ширээн дээр байх зүйлүүдээс өөрт хэрэгтэй шим тэжээлтэй хоол хүнсийг сонгож хэрэглэдэг болоход бидний сургалт чиглэгдэнэ. Сахар, нүүрс ус их орсон амттанаас түрүүлээд амин дэмээр баялаг ногоог сонгож гартаа барьж байвал зөв хооллолттой болж буйн илрэл болох учиртай. Хэт нэг талыг барьсан хоол хүнснээс татгалзаж зөв хооллож сурах нь эрүүл мэндийн байдал төдийгүй зан чанарын төлөвшилд, сэтгэл зүйд чухал ач холбогдолтой. Хэт их сахар, тос агуулсан хүнс хэрэглэх нь хүүхдийн анхаарал төвлөрөлтийг сулруулж, ямар нэг зүйлд донтох эрсдэлийг нэмэгдүүлдэг. Тиймээс хоол хүнс гэдэг бол дан ганц идэж гэдэс цатгалан байхаас илүү зүйл гэдгийг бид ойлгож хооллолт болон хоол хүнсэнд маш их ач холбогдол өгч ажилладаг. Мах, гурил түлхүү хэрэглэдэг монголчуудын хоол хүнсний хэрэглээний хэвшлийг өөрчлөхөд хүүхдэд багаас нь хоол хүнс маш чухал гэдгийг ойлгуулж мэдүүлэхээс эхэлнэ. тооцож хийсэн хоолны цэсээр хүүхдэд шим тэжээлтэй хоол хүнс бэлдэж өгдөг.

4

Мэргэжлийн чадварлаг баг, хамт олон

Сургуулийн өмнөх боловсролын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй мэргэжлийн чадварлаг багш нарыг бүрдүүлсэн, багш нарын 40 гаруй хувь нь мэргэжлийн тэргүүлэх болон заах арга зүйч зэрэгтэй. Хүүхдийн өсөлт, хөгжлийн чиглэлээр салбартаа тэргүүлэх мэргэшсэн чадварлаг гадаад, дотоодын мэргэжилтнүүдтэй идэвхтэй хамтран ажилладаг бөгөөд арга зүйгээр удирдан чиглүүлэх туршлагатай, чадварлаг мэргэжлийн зөвлөх багтай.

5

Боловсон хүчин чадавхижуулах

Байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр ажлын байран дээрээ тасралтгүй суралцах, хөгжих боломжоор хангах бодлого баримталдаг. Үүний тулд боловсон хүчнийг чадавхижуулах цогц хөтөлбөрийг Монгол, Япон улсад бага насны хүүхдийн боловсролын чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн, судлаач, багш нартай хамтран хэрэгжүүлж байна. Жил бүр Япон улсад туршлага судлах хөтөлбөрийг зохион байгуулж нийт багш, ажилтны 80 хувийг уг хөтөлбөрт хамруулаад байна.

6

Хvvхэд төвтэй цэцэрлэг буюу сургалтын шилдэг арга зүйг нэвтрvvлэхийг зорьдог

Бид Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөрийг Япон улсын болоод бусад улс орны сүүлийн үеийн хүүхдийн хөгжлийн чиг хандлагын талаар байнга судалж тэргүүний шилдэг багш нарын сайн туршлагаас суралцаж хөтөлбөрөө байнга баяжуулж хөгжүүлж байдаг. Ялангуяа Япон улсын сургуулийн өмнөх боловсролын туршлагаас суралцан чанартай сайн сургалтын хэрэглэгдэхүүн, үзүүлэн таниулах материалыг сурталтандаа ашиглах зэргээр багш өөрийн багшлах, заах ур чадвар, арга зүйгээ тасралтгүй туршиж дээшлүүлж байдаг.

7

Шинэ монгол эрдмийн хүрээлэнгийн дэргэдэх сургалтын байгууллага

ШМЭХ нь ЕБ-ын Шинэ Монгол сургууль, Шинэ Монгол технологийн дээд сургууль, Шинэ Монгол технологийн дээд сургууль, ЕБ-ын Шинэ Монгол Харүмафүжи сургууль, Бяцхан Монгол салбар цэцэрлэг, Шинэ Монгол Мабүчи тэтгэлгийн сан, Юү лангүэж улаанбаатар япон хэлсний төв, Ачаръя Шинэ Монгол Англи хэлний төв, ЕБС-ийн багшийг дэмжих Жанчив сан гэсэн нийт 9 салбар хэсгүүдээс бүрдэж байна.

Дугуйлангуудын дэлгэрэнгүй мэдээллийг манай веб хуудсаар
дамжуулан дэлгэрэнгүй танилцах боломжтой.
<https://www.byatshanmongol.com/kid-club>

ДУГУЙЛАНГУУД



БУЖИГ



УРАН ЗУРАГ



ДРАММ



ТАЕКВОНДО



СПОРТ ӨРӨЛГ



НАВА



ДҮРСЛЭХ УРЛАГ



ШАТАР



ТӨГӨЛДӨХ ХҮҮР



ДУУ ДУУЛАЛ



ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТӨВ

Зүгээр л нэг өдрийг өнжүүлэх бус хүүхэд хөгжлийн төвийг санал болгож байна...

www.byatshanmongol.mn **+ЧАНАРТАЙ**



ӨГЛӨӨНИЙ АНГИ
08:00-1300



ӨГРҮЙН АНГИ 13:00 - 18:00

- Зүрх сэтгэлийн дасгал хөтөлбөрүүд
- Хөгжүүлэх дугуйлангууд
- Мэдээж маш чанартай хоол хүнс
- Гэрийн даалгавар ч хийлгэх хөтөлбөртэй
- Ментор багшийн нэмэлт мэдлэг олгох хөтөлбөр
- Өдрийн унтлага ч хийх боломжтой шүү дээ
- Өөр та юу хүсэж байна ... ?



БИДНИЙ СОЁЛ ЮУ ВЭ?

Бид суралцагч хүүхдүүддээ
“Бяцхан Монгол” цэцэрлэгийн соёлыг
хэвшүүлэн ажилладаг.



1 МЭНДЛЭХ, ҮДЭХ СОЁЛ ...

Мэндлэх нь харилцаж байгаа хүнийхээ сэтгэлийг хөдөлгөж халуун дулаан харилцаа үүсгэдэг тул эцэг эх хүүхдүүдтэйгээ өглөө бүр найрсгаар мэндчилнэ. Сайн байна уу? Өглөөний мэнд. Та сайхан амарсан уу?, Өдрийн мэнд, Сайхан амраарай хэмээн мэндэлж, үдэх хүндэтгэл үзүүлнэ. Энэ үйлийг өдрийн аль ч цагт цэцэрлэгт орж гарч байгаа бүх хүмүүст хамааруулж соёл болгон хэвшүүлнэ.

2 ХҮНДЛЭХ СОЁЛ ...

Хүүхэд болон багш, ажилчид өдөр бүр хоорондоо хүндэтгэлтэй хандах, бие биенээ ойлгон хүндлэх соёлыг байнга хэвшүүлэх нь цэцэрлэгийн дотоод уур амьсгалыг халуун дулаан болгохоос гадна хүүхдүүдийн ирээдүйн нийгмийн харилцааны суурыг тавьж өгөхөд оршдог. Хүндлэх ёсонд зөв хандлагатай байхыг илүүтэй заадаг.

3 ТАЛАРХАХ СОЁЛ ...

Баярлаж талархаж байгаагаа чин сэтгэлээсээ илэрхийлнэ. Амттай сайхан хоол хийж өгсөнд талархах, Өдрийг надтай хамт өнгөрүүлсэнд талархах, Хайрлаж асарч хамгаалж өгсөнд талархах, Хамт тоглож цагийг зугаатай өнгөрүүлж өгсөнд талархах, Аав ээждээ өсгөж өсгөсөнд нь талархах гэх зэргээр чин сэтгэлээсээ ойлгож ухаарч баярлахад суралцана.

4 ДЭМЖИХ СОЁЛ ...

Энэ соёл нь багш, ажилтнууд болон хүүхэд хэн ч бай хийхийг хүссэн, сонирхсон зүйлээ хийж үзэх, туршиж үзэх боломжоор хангагдан бие биенээ дэмжин хамтдаа суралцах үйлд дэмжлэг үзүүлдэг. Ялангуяа багш бид бүхэн хүүхдийн хүсэл тэмүүлэл сонирхол, авьяас чадварыг аль болох эрт илрүүлэн дэмжиж, дуртай зүйлээр нь дамжуулан сургахад анхаарлаа хандуулах нь чухал юм.

5 МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ ЯЗГУУР СОЁЛ ...

Монгол Хүн монголынхоо уламжлалт өв соёлыг мэдэх зайлшгүй шаардлагатай гэж үзэн бид хүүхдүүддээ Монголын төрт ёсны бэлгэдэл, Хэл яриа, Баяр ёслол, Хоол хүнс, Хөгжим бүжиг, Ном сурах бичиг, Гар урлал, Хувцас эдлэл хэрэглэл буюу уламжлалт аж ахуй гэх мэтчилэн олон төрлийн зүйлсийг зааж сургах, мэдлэг мэдээлэл өгөх томоохон үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Бяцхан Монгол” цэцэрлэгийн загвар цэцэрлэг | # НАЦУМИДА model kindergarten

ГАДААД ХАРИЛЦАА

СУРГАЛТ, ХӨГЖИЛ









Бяцхан үрээ Бяцхан Монгол цэцэрлэгт оруулсандаа баярладаг. Бүр эртнээс төлөвлөж байгаад өгсөн байдаг юм. Хамгийн чухал нь хоолны цэс, хоол нь шинжлэх ухаан байлаа. Хүүхдийн минь идэж сурах хүнс, авах ёстой илчлэг гээд бүгдийг шингээсэн эцэг эхэд хүртэл ойлгомжтой цэгцтэй байлаа.

Бяцхан монгол цэцэрлэгийн сургалтын арга барил ч бусдаас давуу хүү маань тоглонгоо дуу, шүлэг сурч, аливаа юмыг эргэцүүлдэг болсон юм. Хүү минь өглөө бүр цэцэрлэгтээ яарч, орой бүр баяр хөөртэй, эцэг эх бидний хувьд сэтгэл хангалуун байсан. Басхүү хүү минь нийтэч, нээлттэй бас хүнлэг өрөвч хүн болж төлөвшсөн.



Манай хүү цэцэрлэгийнхээ хоолонд үнэхээр дуртай, тэр бүү хэл орой эрт авахад мааш дурамчхан явж, цэцэрлэгийнхээ багш нарын хийсэн амттаныг хааяа машин дотроо бусдад хуваалцахгүйгээр ганцаараа нүүрэндээ инээмсэглэлтэй идэж байгаа тэр мөчүүдийг бид бүхэн хэзээ ч мартдаггүй юм. Ковидтой хөл хориотой байх үед байнга цэцэрлэгийнхээ тухай, багшийнхаа хүүхдүүдийнхээ хөгтэй инээдтэй гэж бодсон зүйлүүдийг ярьж өөрийн сэтгэл дотор байгаа тэр том орон зайгаа хуваалцаж байгааг хараад үнэхээр Батсүмбэрийн мань том болоод амьдралынх нь хамгийн дурсамжтай мөчүүд мартагдахааргүй үлдэж мөн эцэг миний хувьд эргээд хүүхэд болох юмсаа гэсэн бодол төрдөг байлаа. Миний хүүгийн амьдралын хамгийн сайхан дурсамжтай цагийг бүтээлцэж байгаа та бүхэндээ юугаар ч зүйрлэшгүй хамгаас их баярлаж явдгаа дахин дахин хэлмээр санагддаг шүү. Та бүхэндээ энэ сайхан цэцэрлэгийн үнэт зүйлийг бүтээлцэж, амьдралын хамгийн сайхан дурсамжуудыг миний хүүд, манай гэр бүлд өгч байгаад үнэхээр юутай ч зүйрлэшгүй юм шүү.

Хүү маань эрдэм чадалтай, найрсаг багш нарыхаа ачаар тухайлбал эрхлэгч Н.Болормаа, ахлах багш Б.Мядагбадам, туслах багш Б.Оюунцэцэг нараасаа СӨБ-ийг төгс эзэмшсэн учираас Шинэ Монгол сургуульдаа элсэн орох шалгалтаа амжилттай өгч 900 хүүхдээс 6-р байр эзэлсэн билээ. “Шавийн эрдэм багшаас” гэдэг иймд хүүгийн маань элсэлтийн шалгалтаа ийнхүү амжилттай өгсөн нь СӨБ-ийг төгс эзэмшүүлж өгсөн багш нарын маань ач билээ. Бидний балчир үрсийг эрүүл энх өсөн торниулж буй амаргүй ажилд нь амжилт хүсэхийн ялдамд охиныхоо багш болох ахлах багш Б.Гансүх болон танай хамт олонд гүн талархал илэрхийлье. Хүүхэд бүр аз жаргал, инээд хөөр, хүсэл эрмэлзэл дүүрэн эрүүл энх өсөн торних болтугай.



Би анх Бяцхан Монгол цэцэрлэгт аав, ээжтэйгээ хамт хөтлөлцөн орж ирсэн. Намайг орж ирэхэд зөндөө гоё багш нар угтан авч бас маш олон хүүхдүүд аав, ээжтэйгээ ирсэн байсан. Би цэцэрлэгт орохдоо жоохон үйлсэн тэгээд зүгээр сууж байхад нэг сайхан сэтгэлтэй Цэрмаа гэдэг охин надтай танилцаж найзууд болж бие биендээ тусалдаг тийм сайн найзууд болсон. Би багшийнхаа царайг бол мэдэж байна. Гэхдээ нэрийг нь мартаж. Манай багш надад зөндөө юм зааж өгсөн тэрний ачаар би нэгдүгээр ангид орсон. Миний хамгийн дурсамжтай үе бол миний төрсөн өдөр манай цэцэрлэгийн найзууд бүгдээрээ төрсөн өдрийн дуу дуулаад л, бэлэг өгөөд хамгийн гоё өдөр байсан. Би та нартайгаа уулзмаар л байна. Даан ч уулзаж чадахгүй учир надад захиа бичээд өгөөрэй. Би та нартаа хайртай шүү.



nmit
Scientia et Virtus



NEW MONGOL
COLLEGE OF TECHNOLOGY



SHINE MONGOL
MABUCHI
FOUNDATION



Yu Language
Ulaanbaatar



“БЯЦХАН МОНГОЛ” цэцэрлэг-1 (Натур салбар)

Хаяг: БЗД, 25-р хороо, 13-р хороолол, Натурын зам дагуу
152-р байр, 1-Давхар, Утас: 7611-7676/1 товч
И-мэйл хаяг: info_bm2016@byatshanmongol.mn
Цэцэрлэгийн эрхлэгч: М.Мөнххэрлэн, Утас: 99908981

“БЯЦХАН МОНГОЛ” цэцэрлэг-2 (Жапан Таун салбар)

Хаяг: ХУД, 15-р хороо, “Жапан Таун” Хороолол,
С5 Блок, Утас: 7611-7676/2 товч
И-мэйл хаяг: infobm2@byatshanmongol.mn
Цэцэрлэгийн эрхлэгч: Н.Болормаа, Утас: 99074556

“БЯЦХАН МОНГОЛ” цэцэрлэг-3 (Сүүл гарден салбар)

Хаяг: ХУД, 16-р хороо, Нисэх-Яармаг,
“Сүүл Гарден” Хороолол, Утас: 7611-7676/3 товч
И-мэйл хаяг: infobm3@byatshanmongol.mn
Цэцэрлэгийн эрхлэгч: Б.Мэндбаяр, Утас: 94091602

[Facebook page:](#) БЯЦХАН МОНГОЛ цэцэрлэг

[Instagram page:](#) БЯЦХАН МОНГОЛ цэцэрлэг / byatshan_mongol_kindergarten

[Web page:](http://www.byatshanmongol.mn) <http://www.byatshanmongol.mn>, www.byatshanmongol.com